

Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний асуудалд шинжлэх ухаанчаар хандах тухай

A scientific approach to the issue of freedom of religion or non-religion

Мишиг-Ишийн Батаа^{1*}

Доктор (Ph.D)
Шинжлэх Ухааны Академийн
Философийн хүрээлэн
Шашин судлалын салбар
mbataa@gmail.com

Магсаржавын Гантуяа^{1, *}

Доктор (Sc.D)
Шинжлэх Ухааны Академийн
Философийн хүрээлэн
Шашин судлалын салбар
gantuyam@yahoo.com

Х.Амантай^{1,*}

Туркийн Мармара их сургуулийн
докторант
Шинжлэх Ухааны Академийн
Философийн хүрээлэн
Шашин судлалын салбар
meramanhaj@gmail.com

Bataa Mishig-Ish^{1*}

Doctor (Ph.D)
Department of Religious Studies,
Institute of Philosophy,
Mongolian Academy of Sciences
mbataa@gmail.com

Gantuya Magsarjav^{*}

Doctor (ScD), professor
Department of Religious Studies,
Institute of Philosophy,
Mongolian Academy of Sciences
gantuyam@yahoo.com

Amantai, Kh^{*}

Doctorate student of Marmara
University
Department of Religious Studies,
Institute of Philosophy,
Mongolian Academy of Sciences
meramanhaj@gmail.com

Хураангуй:

Бидний хэдэн судлаачид шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний асуудалд шинжлэх ухаанчаар хандах, уламжлалт шашны түүх, үнэт зүйлс, онцлог, нийгэмд гүйцэтгэж буй үүргийг ялгамжтай авч үзэх, энэхүү асуудлыг зохицуулж буй гадны орны туршилагыг судлах зэрэг цогц асуудлыг төрөөс баримтлах бодлого, холбогдох эрх зүйн баримт бичиг боловсруулахад тусгахын ач холбогдлыг харуулсан өгүүллийг толилуулж байна. Бид энэхүү өгүүлэлдээ шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний асуудалд төрөөс хандахдаа шашин судлалын шинжлэх ухааны судалгаанд

Abstract:

Some of our researchers present an academic article that demonstrates a scientific approach to the issue of freedom of religion and non-religion, consider the history, values, features and roles of traditional religions in a different way, and study the experience of foreign countries that regulate this issue, such as government policy on religion and related legal issues. the importance of reflection in document development. In this article, we highlight the importance of relying on scientific research in religious studies when the government approaches the issue of freedom of religion or non-religion, the

¹ © Зохиогчид. 2022. Сэтгүүлд нийтлэгдсэн эрдэм шинжилгээний бүтээл нь зохиогчдийн оюуны өмч байх бөгөөд (CC BY- <https://creativecommons.org/licenses/by/4.0/>) нөхцөлийн хүрээнд ашиглана уу.

* Холбоо барих зохиогч. Бүх зохиогч тэгш оролцоотой.

тулгуурлахын чухлыг болон Монголын уламжлалт шашин хэлмэгдэж, монголчуудын оюун санааны уламжлал тасарсны үр дагавар болон хүний эрхийн түгээмэл тунхаглалуудыг үл зөрчин уламжлалт шашинаа төрөөс дэмжиж, нийгмээ хүчирхэг болгон хөгжүүлж байгаа олон улс орнуудаас Турк Улсыг жишээ болгон танилцуулж байна.

Түлхүүр үгс: шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, уламжлалт шашин, төр, сүм хийдийн харилцаа, шашны байгууллага, шашин судлал, шашны бодлого

consequences of the repression of Mongolian traditional religion, the loss of spiritual traditions of Mongolians, and the fact that the government supports traditional religion and develops a strong society without violating the universal human right declarations on the example of Turkey.

Keywords: freedom of religion or non-religion, traditional religion, church-state relations, religious organization; religious studies and religious policy

I. Оршил

Нэг. Шашинд хандах төрийн ба шашин судлалын шинжлэх ухааны хандлага. 2004 онд тухайн үеийн МУИС-ийн Шашин судлалын тэнхим болон НҮБ-ын Монголд хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөр боловсруулах төслөөс хамтран “Шашин шүтэх, эс шүтэх эрх, эрх чөлөө” сэдвээр эрдэм шинжилгээний симпозиум зохион байгуулж, Монгол улсад бүрэлдэж эхлээд байсан хүний эрх, эрх чөлөөний шинэ хандлагын хүрээнд анх удаа энэхүү сэдвээр нийгэм, хүмүүнлэгийн шинжлэх ухааны янз бүрийн салбарын төлөөлөл-эрдэмтдийн дунд илтгэл, хэлэлцүүлэг өрнүүлэн, симпозиумын материалаар эмхэтгэл гаргасан билээ. Энэхүү эмхэтгэл нь өнөөг хүртэл шашны эрх чөлөөний асуудлаар Монголын эрдэмтэн судлаачдын байр суурийг илэрхийлсэн гарын авлага болж хэрэглэгдсээр ирлээ. Уг эмхэтгэлд бид шашны эрх чөлөөний асуудлыг судлахад баримтлах арга зүйн чиг хандлага, шашны талаарх Монгол төрийн бодлогын уламжлал, тухайн үеийн дэлхийн улс орнууд дахь шашны эрх чөлөөний байдал, шашны эрх чөлөөний талаарх бусад орны болон манай орны эрдэмтдийн болон иргэдийн үзэл баримтлал, ойлголтуудын талаарх илтгэлүүд, санал шүүмжүүдээс гадна энэхүү симпозиумд зориулан тусгайлан 2004 онд Монгол Улсын 21 аймгийн 1000 гаруй иргэдээс авсан социологийн судалгааны дүн, шашин шүтэх, эс шүтэх эрх, эрх чөлөөг хангах Монгол улсын төдийгүй НҮБ-ын Монгол Улсад хүний эрхийг хангах хөтөлбөрөөс гаргасан шашны эрх чөлөөнд холбогдох заалтууд, Хүний эрхийн конвенцүүдийн Хороо, Хүний эрхийн дээд Комиссарын газраас гаргасан 2004 оны ерөнхий санал зөвлөмж зэрэг хууль эрх зүйн холбогдох материалуудыг хавсаргасан юм. Бид шашны эрх чөлөөний асуудалд хандахдаа олон улсын болон Монгол улсын хүрээнд мөрдөгдөж буй хууль тогтоомжуудыг баримтлахаас гадна монголчуудын оюуны соёлын, түүний дотор уламжлалт шашны үнэт зүйлсийг хамгаалах, хойч үедээ уламжлан өвлүүлэх, орчин үеийн дэлхий нийтийн хөгжилд мөр зэрэгцэхүйц боловч үндэсний онцлогтой нийгмийг цогцлоон хөгжүүлэх үүргээ үл умартахыг Монголын иргэддээ ямагт сануулж байхыг чухалчлан хичээж ирлээ. Шашны асуудалд хандах Монголын төрийн бодлогод ч энэ үзэл санаа шингээстэй байх учиртай.

Харин энэ 2022 онд “Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө” хэмээх эмхэтгэлийг МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн, Махони Лиотта

ХХН-ээс хамтран хэвлүүлсэн байх бөгөөд уг эмхэтгэлд “Европын Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны Байгууллага”-ын Шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөний асуудлаарх зөвлөх хэсгийн гишүүн (2022-2025), “BYU Law Review” сэтгүүлийн ерөнхий редактор, Бригхам Янгийн Их сургуулийн Эрх зүй, шашин судлалын олон улсын төвийн дэд захирал, Профессор Элизабет А.Кларк-ийн “Монгол Улсын Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль (1993) болон Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хуулийн төсөл (2018)-д хийсэн дүн шинжилгээ”, МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн захирал, ХЗС-ийн профессор, хууль зүйн ухааны доктор О.Мөнхсайханы “Итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө” хэмээх өгүүллүүдийг, мөн Хүний эрхийн түгээмэл тунхаглал (1948), Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (1966), Монгол Улсын Үндсэн хуулийн (1992) ес, арван дөрөв, арван зургаа, арван есдүгээр зүйл, Монгол улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт (1994.01.02, №02), Төр, сүм хийдийн харилцааны тухай Монгол Улсын Үндсэн хууль (1993), Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал (2018), “Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай” хуулийн төслийн (2018) шинэчилсэн найруулга болон түүний танилцуулгыг хавсаргажээ.

Дээрх хоёр эмхэтгэлийн эхнийх нь шашинд хандах Монгол төрийн уламжлалт бодлого, үндэсний оюуны өв соёлоо хамгаалан хөгжүүлэх үзэл санааг дээдлэн баримталсан бол бол сүүлийнх нь цэвэр хууль эрх зүйн заалтуудыг, чингэхдээ хүний эрхийг тунхагласан олон улсын стандартуудыг үндэс болгож шашны асуудалд хандахыг санал болгосон шинжтэй байна. Ямартай ч Монголын төрөөс шашны асуудалд хандахдаа нэг талаас, олон улсын хүний эрхийн үзэл баримтлалыг, нөгөө талаас, монголчуудын үндэсний уламжлалт оюуны соёлын өвийг хамгаалан үндэсний онцлогоо хадгалах үзэл санааг тусгах гэсэн чухал хоёр талыг аль алиныг нь авч үзэх хэрэгтэй гэдэг нь дээрх хоёр эмхэтгэлийн агуулга, үзэл санаанаас харагдаж байна.

II. Судалгааны арга зүй

Шашны асуудалд хандах нийгэм, хүмүүнлэгийн шинжлэх ухаанч хандлага хэрхэн бүрэлддэг үйл явцыг товчхон тайлбарлая.

Социологийн шинжлэх ухаанд шашны итгэл үнэмшлийг хэд хэдэн шалгуураар тогтоодог юм. Тухайлбал, шашин шүтлэг нь итгэл үнэмшил болж хүлээн зөвшөөрөгдөхийн тулд хэсэг бүлэг итгэгчдийг эгнээндээ багтаасан байх ёстой. Эндээс шашны бүлгүүд нь нийгмийн бусад бүлгүүдээс ямар ялгаатай вэ гэсэн асуудал үүснэ. Шашны нэг гол онцлог нь далдын хийсвэр хүч, ер бусын зүйлтэй холбогддог. Далдын ер бусын хүчинд итгэх итгэл нь хүмүүсийг тэрхүү далдын эерэг хүчтэй холбож ивээл хамгаалалтанд нь оруулах, эсвэл далдын сөрөг хүчнээс ангижруулан аврал энэрэлд багтаах шашны зан үйл рүү хөтөлдөг. Сэтгэл зүйн чухам энэ хэрэгцээ шаардлагаас шашин шүтэх хүмүүний эрхийн асуудал үүсдэг байна.

Шашны зан үйл нь шашны бүлгийн дотоод зохион байгуулалт, сүм хийд, шашны байгууллагын үйл ажиллагааг нөхцөлдүүлдэг. Ийнхүү шашин нь хувь хүн болон нийгмийн сэтгэл зүй, ёс зүй, дэг жаяг, амьдралын хэв маягтай

уялддаг юм. Эндээс өөр өөр шашин шүтлэгтэй хүмүүсийн хооронд сэтгэл зүй, ёс зүй, нийгэмд мөрдөх дэг ёс, амьдралын хэв маягийн ялгаа гарч ирнэ. Ялгаатай шашин шүтлэгтэй хувь хүмүүс болон нийгмийн бүлгүүд харилцан ойлголцох, хүлээцтэй хандах нийгмийн хариуцлагын асуудал үүнээс үүсдэг. Нийгмийн харилцаа нарийсан хөгжихийн хэрээр шашны байгууллагын бүтэц ч улам бүр ээдрээтэй болно. Ялангуяа даяаршил, глобалчлалын эрин үед тодорхой улс үндэстний доторх нийгмийн дэг ёс, амьдралын хэв маягийн нэгдмэл байдлыг хадгалах, харилцан ойлголцлыг тогтооход хил дамнасан шашны байгууллагуудын үйл ажиллагаа нэн нарийн болж ирлээ.

Энэ нөхцөлд, дэлхий нийтийн нийгэм-эдийн засгийн хөгжлийн чиг хандлагад нэгдэх, хил дамнасан шашны байгууллагуудын үйл ажиллагааны хүрээнд хүний шашин шүтэх, эс шүтэх эрхийг болон улс үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолоо хамгаалах, үндэсний уламжлалт оюуны соёлоо өвлөн хөгжүүлж, үндэсний онцлогоо хадгалж үлдээх зэрэг олон асуудлын уулзвар дээр төрөөс шашны бодлогоо тогтоох учиртай.

Шашны байгууллагууд нь хэдийгээр хүмүүсийн шашин шүтлэгт тулгуурлан үүсдэг, шашин шүтлэгийн хэрэгцээ шаардлагаар үйл ажиллагаагаа явуулдаг ч, тодорхой бүлэг хүмүүсийг эгнээндээ нэгтгэсэн гэдэг утгаараа тэднийг улс төрийн болон эдийн засгийн хүчин зүйл болгож хувиргах боломжтой гэдгийг философичид, социологичид онол сургаалдаа олонтаа нотлон тэмдэглэсэн байдаг. НҮБ-ын хүний эрхийн үзэл баримтлалын хүрээнд улс орнууд дахь шашны эрх чөлөөний талаарх хуулийн заалтууд болон тэдгээрийн практик хэрэгжилтийг шүүн тунгаасан тайлангууд жил жилээр гаргасан байх ба эдгээрт шашны асуудалд хандах тодорхой улс үндэстний дотоод өвөрмөц бодлогыг “хүн” гэсэн түгээмэл ерөнхий ойлголтын үүднээс авч үзжээ. Монгол Улсын тухайд, шашны байгууллагуудыг бүртгэх, тодорхой нэг шашныг онцгойлон дэмжих зэрэг асуудлаар шүүмжид өртсөн байх нь элбэг.

Социологийн шинжлэх ухааны үүднээс аливаа шашны байгууллага нь улс төрийн, эдийн засгийн, олон нийтийн зэрэг нийгмийн бусад байгууллагуудтай, ялангуяа төртэй нийгмийн харилцаанд орж байдаг. Шашны байгууллагын гишүүд, сүсэгтнүүд нь нэгэн зэрэг тэдгээр нийгмийн бусад байгууллагын гишүүд байж болох учраас нийгмийн бусад харилцаанд нөлөөлөх боломжтой. Иймээс төрөөс шашны байгууллагад хандахдаа нийгмийн бусад байгууллагад ханддаг нийтлэг хандлагыг илэрхийлэх нь зүй. Ялангуяа улс төрийн болон эдийн засгийн харилцаанд шашны байгууллага нь нийгмийн бусад байгууллагатай ижил байр сууринд байх зүй тогтлыг төр, шашны харилцааны хуулиндаа ямар нэг байдлаар тусгах хэрэгтэй ба энэ нь хүний шашин шүтэх эрх чөлөөнд халдаж байгаа хэрэг биш, харин аливаа нийгмийн байгууллага үүсэж хөгжих зүй тогтлын тухай нийгэм судлалын шинжлэх ухаанаар тогтоосон хууль зарчмуудыг харгалзсан хэрэг. Ялангуяа улс төрийн болон эдийн засгийн харилцаанд аль нэг нийгмийн байгууллагад давуу эрх олгох нь эргээд нийгмийн харилцааны тэнцвэрт байдлыг алдагдуулах сөрөг үр дагавартай учир үүнээс сэргийлсэн хууль тогтоомжуудыг улс орнууд гаргадаг байна. Үндэсний оюун санааны уламжлал, дархлаажилтыг хадгалах үүднээс гаргаж буй хуулийн заалт нь улс төрийн ба эдийн засгийн давуу байдлыг үүсгэх шалтгаан байж хэрхэвч болохгүй. Иймээс төр, шашны харилцааны асуудал дээр хүн төрөлхтөний

түгээмэл харилцаа, үндэсний уламжлалт соёлын өвийг хадгалах болон улс төрийн, эдийн засгийн зэрэг нийгмийн харилцааны асуудлуудыг цогцоор нь бодолцох хэрэгтэй болдог.

Шашин нь хүмүүсийг тодорхой чиг үүргийн хүрээнд нэгтгэдэг учраас улс үндэстнүүд нийгмийн харилцааны дотоод эв нэгдэл, харилцан ойлголцол, тасралтгүй хадгалагдах соёлын уламжлал, ялангуяа хүн ардын ёсзүйн нэгдмэл хүмүүжил төлөвшлийг тогтоох үүднээс төрөөс аль нэг шашныг дэмжих байр суурь барьдаг нь олон олон улс орны жишээн дээрээс харагдаж байна. Шашин энэ чиг үүргээ алдах, эсвэл ийм чиг үүрэг гүйцэтгэж байсан шашныг устгах нь нийгмийн харилцааг тогторгүйжүүлэх шалтгаан болдог. Монголчуудын хувьд нэн эрт үеэс өвөг дээдсээс тасралтгүй өртөөлөн уламжилсан өв соёл, хүндлэн биширдэг шашин шүтлэг, нандигнан дээдэлдэг үнэт зүйлсийг нь ХХ зууны эхний хагаст улс төр, үзэл суртлын зорилгоор үндсээр нь устгаснаар нийгмийн дотоод эв нэгдэл алдагдаж, үл ойлголцол, хэрүүл тэмцэл, агаа жөтөө, хувиа хичээсэн аминч үзэл, бусдыг үл тоомсорлох омог дээрэнгүй хандлага өнөөгийн нийгмийн харилцаанд нийтлэг үзэгдэл болжээ. Гэтэл тэр бүх өв соёлоо хичээнгүйлэн хадгалсан улс гүрнүүд хэрхэн хөгжиж дээшилж байгааг Өрнө, Дорнын олон улс орны жишээгээр нотолж болно. Өрнийн соёл иргэншлийн хөгжлийн нууц нь Протестант шашны ёс зүйн сургаалд оршино хэмээн социологийн шинжлэх ухааны эцэг Макс Вебер өөрийн алдарт шинжлэх ухааны бүтээлдээ нэгэнтээ батлан тогтоосон байдаг. Монголчуудын хувьд ч ХШ зууны Монголын хаад язгууртны баримталж хэрэгжүүлсэн тэнгэр шүтлэг болон ХХ зууны эхэн үеийн Богд хаант Монгол улсын тусгаар тогтнолыг зарласан монголчуудын ертөнцийг үзэх Буддын үзэл баримтлал аль аль нь монголчуудын хүчирхэгжин дэвжихийн нэгэн гол шалтгаан болж байв. Оюуны соёлын энэхүү хүчирхэг уламжлал тасрах бүрийд Монголын нийгмийн харилцаа уруудан доройтож байлаа.

МУИС-ийн Шашин судлалын тэнхмийн эрхлэгч агсан доктор Г.Лхагвасүрэн “Шашны талаарх Монгол төрийн бодлогын уламжлалаас”[1] хэмээх илтгэлдээ: *«Монгол төрийн мандал, буурлын аль ч үед шашны асуудал төрийн бодлогод ямар нэгэн хоёрдугаар зэргийн, тохиолдлын мэт зүйл байсангүй. Харин ч нийт нийгмийг оюуны хувьд нь нэгтгэн нягтруулах, үндэсний өвөрмөц дүр төрх, оюуны тусгаар тогтнолоо хадгалан бэхжүүлэх нэгэн гол хүчин болох хувьд нь шашны асуудлыг авч үздэг байжээ. Төрийн байгуулал, шашин сүм хийдийн байгуулал хоёрыг зэрэгцүүлэн босгож, шашнаа уг номын нь ёсоор явуулах үндсэн дээр төрийн албадагын хүчийг шашин номын хүчин лүгээ хавсаргаж, тэр хоёр бие биеэ нөхөн гүйцээж, шүтэн барилдаж чадсан цагт сая төр улс төвшин бөгөөд амгалан болж чадна гэж үздэгт шашны талаарх Монгол төрийн уламжлалт бодлогын гол зүйл орших юм гэж үзэж байна»* хэмээн шашны талаар явуулж ирсэн Монгол төрийн уламжлалт бодлогыг тодорхойлсон байдаг.

Өнөө мөрдөгдөж буй “Төр, сүм хийдийн харилцааны тухай” хууль нь Монгол Улсын “иргэний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хангах баталгааг тогтоож, төр, сүм хийдийн хоорондын харилцааг зохицуулах” зорилготой. Үүнд, аливаа шашныг шүтэх буюу эс шүтэх нь тухайн хүний итгэл үнэмшлийн хэрэг байна, иргэнийг шашин шүтэх, эс шүтэхэд албадах, эрх чөлөөг нь

хязгаарлахыг хориглоно, иргэдийг шашин шүтлэгийн ялгаа болон шашин шүтэх, эс шүтэх байдлаар нь ялгаварлан гадуурхах, доромжлох, хагалан бутаргах үйл ажиллагаа явуулахыг хориглоно гэх мэтээр хүний эрхийн түгээмэл заалтуудыг тусгасан болно. Уг хуулиар Монголын төр, сүм хийдийн харилцааны үндэс нь “төр нь шашнаа хүндэтгэж, шашин нь төрөө дээдлэх” явдал юм. Энэ нь өмнө өмнөх үеийн Монголын төр, шашны бодлогын гүн ухааны үзэл санааг тусгасан чухал заалт билээ. Тухайлбал, төрийн нэгдсэн бодлого бол Монгол Улсын хэмжээнд хэрэгжүүлж буй бүхий л бодлогын, түүний дотор шашны бодлогын суурь үндэс нь байна, шашны бодлого бол эдийн засгийн, боловсролын, байгаль хамгаалах зэрэг Монгол төрийн бусад бүх бодлогуудтай нягт уялдан, нэгдсэн төрийн бодлогод захирагдах учиртай, чингэхдээ төр нь шашныг дорд үзэх, ялгаварлан гадуурхах, үл тоомсорлох байр суурийг хориглож, шашныг хүндэтгэх хандлагыг дэмжихээ илэрхийлсэн хэрэг юм.

Төр шашны харилцаа ямар байвал хамгийн зохимжтой вэ гэсэн асуултад гадаад дотоодын ихэнх судлаачид “төр нь шашин шүтэх, эс шүтэх эрх, эрх чөлөөг хамгаалж дэмжиж байхад шашин нь төрийнхөө тусгаар тогтнол, иргэдийн амар тайван байдлыг хамгаалахад хүчин зүтгэж байвал төр, шашны харилцаа сая зөв явагдаж байна” гэж үздэг. Төрөөс шашны асуудлыг хамгийн зөв арга замаар шийдвэрлэх, шашны байгууллага, сүсэгтэн хүмүүстэй харилцах хамгийн зөв хандлагаа тогтоохын тулд Шашин судлалыг шинжлэх ухааны салбар болох хувьд нь дэмжин хөгжүүлж, шашин судлаачдыг шашны асуудал эрхэлсэн төрийн үйл хэрэгт татан оролцуулах зайлшгүй шаардлага улам бүр өсөж байна. Шашин судлал гэдэг бол шашнаас ангид тусдаа байж, шашныг олон талаас судлан объектив мөн чанарыг нь тодорхойлох шинжлэх ухааны салбар болохоос шашныг баримталдаг, эсвэл шүүмжилдэг байр суурьтай субъект биш юм. Энэ утгаараа төр нь шашны асуудалд хандахдаа шашин судлалын шинжилгээ судалгааг үндэс болговол зохино.

Бид энэхүү өгүүлэлдээ Монголын уламжлалт шашин хэлмэгдэж, монголчуудын оюун санааны уламжлалт тасарсны үр дагавар болон хүний эрхийн түгээмэл тунхаглалуудыг үл зөрчин уламжлалт шашнаа төрөөс дэмжиж, нийгмээ хүчирхэг болгон хөгжүүлж байгаа олон улс орнуудаас Турк Улсыг жишээ болгон танилцуулж байна.

III. Судалгааны үр дүн

Хоёр. Шашин шүтэх, эс шүтэх эрх, эрх чөлөө ба уламжлалт шашны статус. Хүний эрх, эрх чөлөөг дээдлэх үндсэн зарчим бүхий ардчилсан тогтолцоог нийгэм, улс төр, эдийн засгийн харилцааны суурь болгоод 30 гаруй жилийн нүүр үзэж буй монголчуудын шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний талаарх ойлголт харилцан адилгүй байна. Энэхүү асуудал нь нэгдүгээрт, түүхийн нугчаанд хөгжин мандаж, хэлмэгдэн устаж байсан уламжлалт шашин нь монголчуудын түүх, соёл, өв уламжлалын үнэт зүйлстэй холбогдох асуудал; хоёрдугаарт, өнөөгийн нийгэм дэх шашны дотоод, гадаад нөхцөл байдлын асуудал; гуравдугаарт, гадаад улс орны туршлага, сургамж, дөрөвдүгээрт, төрөөс шашны талаар баримтлах бодлогыг үр нөлөөтэй боловсруулах зэрэг цогц асуудал болох юм.

Сүүлийн зуу гаруй жилийн түүхийг товч сөхөхөд, 1911 онд Манж гүрнээс тургга тусгаарласан Монгол улсад үндэсний шашин, соёлыг дээдлэх үзэл санаа сэргээд төдийлэн удаагүй байхад буюу 1920-иод оны хоёрдугаар хагаст Коминтерны Монгол дахь үйл ажиллагаа идэвхжиж, Зөвлөлт засгийн төлөөлөл засаг төрийн бодлого, үйл ажиллагааг бүрэн хяналтандаа авснаар уламжлалт Бурханы шашны лам хуврагууд, сүм хийдүүдийн хөрөнгө хураах, татвар оногдуулах, лам нарыг баривчлан хорих зэрэг үйл ажиллагаа явуулан, хэлмэгдүүлэлтийг эхлүүлсэн байдаг.

Энэхүү хэлмэгдүүлэлт буюу гадны бодлогоор уршигдсан уламжлалт шашны устгал нь 1938 онд оргил үедээ хүрч, нийт сүм хийдүүдийн үйл ажиллагааг бүрэн зогсоож, хутагт хувилгаад, хэргэмтэн мяндагтнууд, эрдэмт лам хуврагуудыг олноор цаазлан егүүтгэж, үлдсэн хуврагуудын давхаргыг шорон гянданд хорьж, нөгөө хэсгийг нь хар бор ажил, цэрэг татлагад дайчлан хамруулах зэргээр уламжлалт шашин соёлыг үндсэндээ устгажээ.

Түүхийн эх сурвалж бүхий хэдэн тоо дурдахад л хэлмэгдүүлэлт ямар өргөн цар хүрээтэй, нарийн зохион байгуулалттай, хурдацтай өрнөснийг харж болно. Зөвхөн 1938 онд 767 сүм хийдийг бүрэн хаасан, 1939 онд (тэдгээрээс) 730 сүм хийдийн барилгыг олон нийтийн байгууллагад шилжүүлсэн гэх тоо мэдээ байна[2]. Зарим сүм хийдийг 1938 оноос өмнө хийгээд 1939 оноос хойш ч үргэжлүүлэн хааж байсныг энд дурдах нь зөв. Нийт улс төрийн хэлмэгдэгсдийн дунд лам хуврагуудын эзлэх хувь өндөр байсныг нотолж “зөвхөн 1937-1939 онд 20300 гаруй лам нарыг дайчлан баривчилж, олонхийг нь цаазаар авч, нэлээд тооны лам нарыг ЗХУ-д аваачсан”[3] болон “1933-аас 1953 онд нийт 36000 хүнийг хилсээр баривчилсан”, тэдний дунд 21000 лам нар байснаас 18000 нь цаазлагдсан тухай манай эрдэмтэн түүхчид бүтээлдээ дурджээ[4].

1940-өөд оноос 1990 он хүртэл иргэдийн шашин шүтэх эрх нь Үндсэн хуулиндаа бэлгэ тэмдгийн шинжтэй тусгагдсан ч тухайн үед хүчтэй оршин тогтнож байсан шашингүйн үзлийн уршигаар аливаа шашин шүтлэг, итгэл үнэмшил, зан үйлийг хоцрогдсон нийгмийн хорт үзэгдэл хэмээн үзэж байв. Тиймээс социалист нийгмийн үед шашин шүтлэгийн өөрчлөлтийг дагаад нийгмийн оюун санаа, сэтгэлгээний үнэт зүйлс ч хувьсан өөрчлөгдөж, төрөөс шашны талаар баримтлах бодлого, үйл ажиллагаа нь бүрэн үзэл сурталжсан агуулга, хэлбэртэй байжээ. Тийнхүү монголчууд хүмүүний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний талаар ярих, судлах, бичих, санаа бодлоо илэрхийлэх ямар ч боломжгүй байсаар 1990 онтой золгосон юм.

Ардчилсан өөрчлөлт, шинэчлэлийн эхний жилүүдэд Монголын төр уламжлалт Бурханы шашныг хэлмэгдүүлсэн нь хэдэн зуунаар оршин тогтносон нийгмийн үзэл санаа, өв соёл, үнэт зүйлсийг устган доройтуулсан, түүхэн харгислал байсныг хүлээн зөвшөөрч, хэлмэгдсэн иргэдийг цагаатгах, нөхөн олговор олгох ажлыг эхлүүлсэн байдаг.

Мөн үеэс шашин шүтэх эрх, эрх чөлөөг иргэд бодтой мэдрэх болсон, төр, сүм хийдийн болон иргэдийн шашин шүтлэгтэй холбоотой нийгмийн харилцаанд томоохон өөрчлөлт гарсан, олон шашны сүм хийдийн үйл ажиллагаа идэвхжсэн зэрэг шалтгаан, нөхцлөөс хамааран төрийн зүгээс шашны асуудлыг үр нөлөөтэй шийдвэрлэх бодлого, эрх зүйн зохицуулалт зайлшгүй шаардлагатай болсон юм.

Харамсалтай нь социалист нийгмийн үеийн шашны талаарх буруу ойлголт, зөрүү үнэлэмж нь нийгмийн тодорхой давхаргын хүн амын үзэл бодолд нөлөөлсөн хэвээр байна. Мөн сүүлийн 30 гаруй жилд уламжлалт Бурханы шашин сэргэхийн зэрэгцээ, гадны шашны олон урсгал чиглэлээс шашны үйл ажиллагаа явуулж буй байдал, олон нийтийн дунд шашны талаарх ойлголт, мэдлэг дулимаг байгаа, нийгэм дэх шашны нөхцөл байдлын талаарх чанартай судалгаа цөөн, хийгдсэн судалгааг төрийн бодлого боловсруулахад ашигладаггүй, эрх зүйн үр нөлөөтэй зохицуулалт сул байгаа зэргийг дурдаж болно.

Шашин шүтэх эрх, эрх чөлөө хангагдсан өнөө үед олон нийтийн уламжлалт Бурханы шашин болон уламжлалт бус, шинээр орж ирсэн шашны талаарх бодол санаа, байр суурийг тандсан хэд хэдэн судалгаа хийгдсэний заримын үр дүнг энэхүү өгүүллийн агуулгын хүрээнд товч танилцуулах нь ач холбогдолтой гэж үзлээ.

Хот, хөдөөгийн 3200 иргэнийг хамарсан олон нийтийн санаа бодлын судалгаагаар “судалгаанд оролцогчдын 67.4 хувь буюу 2042 хүн хэлмэгдүүлэлт нь монголчуудын үндэсний өв соёл болон Бурханы шашны үнэт зүйлс устаж үгүй болоход сөргөөр нөлөөлсөн”[5], мөн 88.5 хувь нь “уламжлалт Бурханы шашин бол монголчуудын түүх, соёлын салшгүй хэсэг”[6] хэмээн үзжээ.

Номын гурван хүрдэн сангаас 2017 онд гаргасан судалгааны бүтээлд “судалгаанд оролцогчдын 70.6 хувь нь Бурханы шашин манай уламжлалт шашин мөн гэдэгтэй санал нийлсэн”[7] нь бараг бүрэн устгагдах хэмжээнд байсан шашнаа олон нийт уламжлалт шашин хэмээн үзэж буйн баталгаа юм.

Монгол Улсад дэлхийн зонхилох шашнууд болох Христ, Исламын уламжлалт урсгал чиглэлүүд шашны үйл ажиллагаа явуулсаар 30-аад жил болж, тэдгээрийг дагагч сүсэгтнүүдийн тоо жилээс жилд нэмэгдсээр байгаа. Үүнээс гадна, богино хугацаанд дэлхийн олон оронд үйл ажиллагаагаа эрчимжүүлж буй шинэ шашны байгууллагууд ч Монгол Улсад маш идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа нь тодорхой болсон. Энэ талаар “50000 орчим иргэн” “шинэ шашны 49 өөр урсгалын 150 гаруй шашны байгууллагад харьяалагддаг” гэсэн судалгааг ШГУА-ийн Философийн хүрээлэнгээс гаргасан байна[8].

1993 онд батлагдсан, одоо хүчин төгөлдөр хэрэгжиж буй “Төр, сүм хийдийн харилцааны тухай” хууль нь өнөөгийн нийгэм дэх шашны харилцааг бүрэн зохицуулж чадахгүй байгаа. Энэ талаар Элизабет А.Кларк бичихдээ, бүртгэл нь хялбар, ил тодорхой бус, шашны номыг дэлгэрүүлэхэд хязгаарлалт тавьсан, үндэсний аюулгүй байдалд эрсдэл учруулсан тохиолдолд шашны ажиллагааг түдгэлзүүлэх зэрэг заалтууд байгааг дурдсан байна[9]. Шашны байгууллагын бүртгэл, зөвшөөрлийн асуудлыг үр дүнтэй зохицуулах явдал нь зайлшгүй зохицуулах асуудлын нэг мөн бөгөөд чингэхдээ уламжлалт шашны сүм хийдийн онцлог, нийгэмд гүйцэтгэж буй үүргийг тусгайлан анхаарах нь зөв юм. Олон шашны байгууллагууд бүртгэлгүй, зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулдаг талаар энэхүү чиг үүргийг хэрэгжүүлдэг төрийн байгууллагуудын тайланд тогтмол дурдагддаг.

Уламжлалт шашнаа устгаж, хэлмэгдүүлж байгаагүй хөгжингүй орнуудын жишээг анхааран судлахад, тэдгээр нь уламжлалт шашин шүтлэгийнхээ

зонхилох байр суурийг бататган дэмжсэн төрийн бодлоготой байдаг бөгөөд энэхүү бодлогын гол дэмжлэг нь тухайн улс орны шашны боловсролын салбар дахь дэмжлэг, татварын бодлогын хөнгөлөлтөөр илэрдэг нь нийтлэг ажиглагддаг.

Зүүн Европын ихэнх улс орнууд уламжлалт шашин, сүм хийдээ гадны нөлөөгөөр хэлмэгдүүлсэн түүхэн сургамжтай үндэстнүүд юм. Хуучин социалист тогтолцооноос ардчилсан нийгэмд шилжих үед тэдгээр улсууд уламжлалт шашин, соёлоо сэргээхэд ихээхэн анхаарч, төрийн бодлогоор санхүүгийн дэмжлэг үзүүлж, шашны боловсрол, үйл ажиллагааг нь дэмжиж буй жишээ нэлээд байдаг.

IV. Хэлэлцүүлэг

Уламжлалт шашнаа дэмжин хөгжиж байгаа орнуудын нэгэн жишээ. Энэ асуудлыг Монгол Улстай хууль эрх зүйн хувьд төстэй, гэхдээ өөр шашны уламжлалт соёл давамгайлсан БНТУ-ын жишээн дээр харууля. Чингэхдээ эхлээд АНУ-ын шашны эрх чөлөөний тайлан дээр Туркийн шашны байдлыг хэрхэн шүүмжилснийг авч үзээд, түүний дараа БНТУ-ын зүгээс тэрхүү шүүмжлэлд хэрхэн хандсаныг харууля.

Дундад зуунаас дамжин ирсэн Османы эзэнт гүрний шууд залгамжлал болсон өнөөгийн Турк улс нь 20-р зууны эхээр Үндсэн хуульт засаглалтай, Бүгд Найрамдах улс болсноо тунхаглахдаа уламжлалт Ислам шашнаа төрийн шашнаа гэж үзэж байснаасаа татгалзан,*1928 онд өөрчлөлт оруулж секуляр үзэл баримтлалыг Үндсэн хуулийнхаа гол үзэл баримтлалуудын нэг болгон тунхагласан байдаг. Чингэхдээ Кемализмын үзэл баримтлалыг дэмжсэн, гэхдээ орчин үеийн, ардчилсан секуляр төр нийгмийг цогцлохын төлөө үүнийг хийсэн байдаг.

Одоогоор Туркийн хүн амын бараг 98 хувь нь Ислам шашинтай, үлдсэн цөөн хувьд нь Христийн, Грекийн үнэн алдартны шашин хийгээд Иудайн шашин багтдаг, исламын шашин соёл зонхилсон улс орон юм. Чингэхдээ нийт ислам шашинтнуудын 90% нь Суннит урсгал чиглэлийг баримталдаг бөгөөд 10% гаруй хувь нь шийт урсгал, тэр дундаа Алеви гэх нэршилтэй уламжлалт шийт урсгалаа дагадаг байна.

БНТУ нь Үндсэн хуульдаа секуляр үзэл баримтлалыг тунхаглаад цөөнгүй хугацаа өнгөрсөн ч түүхэн уламжлалынхаа нөлөөгөөр исламын шашин, соёлын нөлөө маш хүчтэй байсаар ирсэн нь зүй ёсны үзэгдэл юм. Сүүлийн үед буюу шинэ мянган эхэлснээс хойш энэ нөхцөл байдлыг нь АНУ-ын талаас үе үе шүүмжилж эхлэх болсон бөгөөд үүнийгээ Шашны эрх чөлөөний тайлан* гэх бичиг баримтдаа ил тод тайлагнан, улс орны уламжлалт соёл, шашны байдалд хөндлөнгөөс үнэлэлт дүгнэлт өгөх болсон байдаг.

* БНТУ анх 1921 онд анхны Үндсэн хуулиа баталсан байдаг бөгөөд үүний дараа 1924 онд түүнийгээ бүрэн шинэчилж 1960 он хүртэл хэрэглэсэн байдаг.

* International Religious Freedom Report гэх тайланг АНУ-ын засгийн газар улс орон бүрдээр гаргах болсон байдаг. Энэ нь цэвэр эрдэм шинжилгээний судалгааны бүтээл гэхээсээ илүү АНУ-ын төр засгаас гаргаж буй бодлогын чанартай илтгэл, тайлангууд болж харагдаж байгаа юм.

АНУ-ын олон улсын шашны эрх чөлөөний хороо Туркийн шашны байдлын талаарх тайлангаа 2006 оноос хойш хийж эхэлжээ. Судалгаандаа гол төлөв нийгэм дэх шашны цөөнх болон тэд өөрсдийн сүсэгтнүүдээ сургаж бэлтгэх үйл явц хэр саад тотгортой байгаа, шашны цөөнхүүд шинэ шашны сүм хийдээ барьж байгуулахад учирч буй саад бэрхшээлүүд, Шашны Жемевин урсгалын нийгэмд эзлэх байр суурийн асуудал, антисемитизм, шашны эсрэг үзэн ядалтыг дэвэргэх, шашны итгэл үнэмшил дээр тулгуурлан цэрэгт явахаас татгалзах асуудал, шашны албадан сургалтын асуудал, шашны аж ахуй эрхлэлт хүн ам дотор онцлог мөн чанар болж чадаж байгаа эсэх тухай асуудлуудыг авч үзэн шашны цөөнхийг гол асуудлуудын сэдэв болгон авч үзсэн байдаг[10]. Үүн дээр нэмээд шашны хувцаслалтын асуудал ордог байсан ч 2016 оноос хойш энэ сэдэв тайлангаас хасагдсан байна.

Судлаач Үнлүгийн (Ünlü) үзэж байгаагаар[11] Турк улсад шашны цөөнхийн эрх системтэйгээр доройтоогүй байгаа ч, 2012 оноос хойш Туркийн шашны байдлын ерөнхий дүр төрх өөрчлөгдсөн нь ажиглагддаг. Энэ өөрчлөлтийн учир нь хоёр улсын харилцааны өвөрмөц шинжээс, өөрөөр хэлбэл өвөрмөц гадаад бодлогын үйл ажиллагаанаас үүдэлтэй болно. Мөн энэ нь шашны цөөнхийн нийгмийн бодит байдал, ямар улс төрийн уур амьсгалд байгаагийн тусгал байж болно гэж үзжээ.

2019 оны тайланд Туркийн засгийн газар Алеви гэх исламын урсгалыг уламжлалт бус шашны сект гэж тунхагласан байдаг тухай өгүүлжээ. Хэдийгээр Туркийн Дээд шүүх Алевичуудын сүм хийдүүд болох Жемевинуудыг шашны мөргөлийн газар гэдгийг хүлээн зөвшөөрсөн байдаг ч, Алевичууд нь өөрсдөө тэдгээр мөргөлийн газрыг хүлээн зөвшөөрөөгүй байна. Өөр нэг том шүүмжлэл бол Туркийн засгийн газар өөрсдийн суннит исламын сургалтын төвүүдийг өргөнөөр нээж, шашны сургалтын үйл ажиллагаа явуулж буй боловч шашны бусад байгууллагын сургалтын үйл ажиллагааг хавчин хязгаарлаж байна гэж шүүмжилдэг[12]. Шашны хэрэг эрхлэх газар нь улс төрийн институт болчихсоныг сөрөг хүчний талынхан сүүлийн үед их шүүмжлэх болжээ. Мөн тайланд сүмийн шашны ажилтан, санваартнууд хүртэл сүмийн удирдлага шийдвэрүүд шударга бус, хэт улс төржиж байгааг нотолсон жишээнүүд хүртэл татжээ.

2020 онд шашны тайлан нь өмнөх оныхтойгоо төстэй байсан боловч Гэгээн Софигийн нэрэмжит сүмийг зөвхөн үзмэрийн зориулалтаар биш, бас нийтийн мөргөлийн сүм болгон хувиргаж, мөн үүнтэй адилаар Византийн үед харьяалагдах Хора музейг бас нийгмийн болон гадаадынхны эсэргүүцэл шүүмжлэлийн эсрэг мөргөлийн сүм болгох статусыг зөвшөөрсөн нь онцлогтой гэсэн байв.

Мөн тайланд, Шашин шүтлэгийн эрх чөлөөний хүрээнд сөрөг хүчнийхэн олон нийтийн сүлжээгээр хийсэн пост нийтлэлийнх нь төлөө байнга буруутгадгаас гадна сөрөг хүчний хэвлэлүүд ч мөн адил засгийн газрын дарамт шахалтад өртөж байгаа талаар дурдсан байдаг. Онцлууштай нь Цөөнхийг хууль ёсны дагуу хүлээн зөвшөөрүүлэх оролдлого нааштай үр дүнд хүрэхгүй байгаагаас гадна, томоохон шоронгуудад төрөөс үзүүлж буй шашны үйлчилгээ нь зөвхөн суннит, ислам шашинтнуудад зориулагдаж, шашны хичээлийг заавал үзэх байдал үргэлжилж, төр засаг санхүүгийн эх үүсвэрийг зөвхөн суннит

урсгалд хуваарилдаг гэсэн дүгнэлт гаргасан байна. Үүнээс гадна ислам шашинтай уйгуруудыг Туркээс албадан нутаг буцаах тохиолдол гараагүй гэжээ[13] гэсэн байдаг.

2021 онд хийсэн шашны эрх чөлөөний тайлан ч мөн нэлээд сөрөг хандлагатай байв. Төр засаг шашны цөөнхөд болон шашны эрх чөлөөнд найрсаг бус хандаж байгааг онцолсон байна. Шашны эрх чөлөөтэй холбоотой мэдэгдлүүдийн хариуд ямар нэг арга хэмжээ авагдахгүй, үйлдэл хийгдэхгүй байгааг дурдаж ийнхүү олон жил үргэлжилж байгаа асуудлуудыг шийдэх дээр ямар ч нааштай арга авахгүй байгааг шүүмжилсэн байдаг. Гэхдээ хамгийн чухал шүүмжлэл нь Туркийн засаг төр шашны үзэн ядалт, хүчирхийллийн эсрэг ямар ч арга хэмжээ авахгүй байгааг онцолсон хэрэг юм. Мөн тайланд Туркийн өнөөгийн нөхцөл байдлын тухай дэлгэрэнгүй дурдаж, тус улсыг анхааралтай авч үзэж байх улс орнуудын тоонд оруулсан байдаг[14].

Шашны эрх чөлөөний хүрээнд хийгдэж буй энэхүү Туркийн талаар АНУ-аас нийтэлсэн тайлангуудыг “идэвхгүй секуляризм” гэсэн ойлголтын хүрээнд авч үзэж байна. Ерөнхийд нь авч үзвэл идэвхгүй секуляризм нь олон нийтийн хүрээнд бусад шашинд илүү их орон зай үлдээдэг[15]. Харин 2021 оны тайлан нь Засгийн газар энэ үзэл баримтлалаас хэтэрч гажуудсан гэдгийг харуулж байгаагаараа ач холбогдолтой. Гэсэн хэдий ч Туркийн засаг уламжлал болсон өөрийн шашин шүтлэгээ хамгаалж хөгжүүлэх чиглэлээр тууштай явж байгаа бөгөөд нэг шашны уламжлал соёл давамгайлсан улс орнуудад ийм онцлог байх нь жам ёсны хэрэг бөгөөд улс оронд ардчилал хөгжиж, шашин шүтэх эрх, эрх чөлөөний ухамсар төлөвшин тогтнолоо тодорхой цаг хугацаа шаардагдах нь зүй ёсны хэрэг юм. Үүний эсрэг БНТУ-ын зүгээс ямар хариу үндэслэл барьж байгааг авч үзье.

Туркийн шашин шүтэх эрх чөлөөний талаар АНУ-ын зүгээс нийтэлсэн тайлангууд нь үнэн хэрэгтээ бодит байдлаас хол зөрж байна гэж Туркийн тал үзэж байгаа юм. Тухайлбал, ГХЯ-ны хэвлэлийн төлөөлөгч Хами Аксой 2020 онд нийтэлсэн тайлантай холбогдуулан хийсэн мэдэгдэлдээ: “Тайлан нь өмнөх жилүүдийн адил үндэслэлгүй, тодорхойгүй, хоёрдмол утгатай мэдэгдлүүдийг агуулсан бөгөөд хувь хүнд тохиолдсон үйл явдлыг шашин шүтлэгийн эрх чөлөөнд халдсан хэмээн албадан буруутгахыг оролдсон”[16] гэж хэлж байв.

Энд нэг зүйл онцлох ёстой, Туркуудын тайлбарлаж буй хандлага юу вэ гэвэл, Турк улсад шашны үйл ажиллагааг Шашны хэрэг эрхлэх газар гүйцэтгэдэг ч, Турк улс аливаа шашны асуудлыг тухайн байгууллагын хүрээнд бус төрийн нэрийн өмнөөс шийдвэрлэдэг. Өөрөөр хэлбэл, Шашны хэрэг эрхлэх газар нь хүнд суртал бүхий институц биш, харин Төрийн аливаа шийдвэрийг төрийн нэрийн өмнөөс гүйцэтгэж буй байгууллага юм гэдэг талаас нь авч үзэж буй.

Туркийн тал АНУ-ын шашны тайлангийн шүүмжлэлийг хоёр улсын хоорондын харилцаа болон 2016 оны 7 сарын 15-нд болсон төрийн эргэлт хийх гэсэн оролдлого дээр тулгуурлаж байна гэж үзэж байгаа бөгөөд үүн дээр тулгуурлан Туркийн тал 2 үндэслэл гаргаж ирж байгаа юм. Нэгд, Туркийн төр засгийн зүгээс “Фетуллах Гюленийг” террорист байгууллагын манлайлагч гэж үздэг бол АНУ-ын тайланд түүнийг “шашны хүн” гэж үзсэн байдаг. Хоёрт, АНУ-ын зорилго бол нь олон улсад өөрийн ашиг сонирхлыг хамгаалах

зорилготой болохоос бус яг шашны эрх чөлөөний талаар ямар нэг тодорхой зүйл бичээгүй, зөрчилтэй мэдээллүүд тавьснаар харагдаж байна гэж үзсэн байдаг.

Турк улсын Засгийн газраас 2021 оны 3-р сарын 2-нд гаргасан “Хүний эрхийн үйл ажиллагааны хөтөлбөрт” хүний эрхийн олон янзын асуудалд засгийн газар хэрхэн хандах хандлагыг тусгасан байдаг. Энэхүү Хүний эрхийн үйл ажиллагааны хөтөлбөрт Турк улсын засгийн газар бусад салбарын нэгэн адил шашин шүтэх эрх, эрх чөлөөнд хандах хандлага, мөн АНУ-ын тайлангийн эсрэг үндэслэлүүдийг тусгасан байна. Туркийн нийгмийн дийлэнх хувийг исламын шашинтнууд бүрдүүлдэг ч, шашны цөөнх нь ч мөн нийтлэг түүх, соёлтой байдгийг тэмдэглэсэн аж. Тийм ч учраас 2002, 2003, 2008 онуудад баталсан[17] хуулийн нэмэлт өөрчлөлтүүдээр мусульманы бус шашны нийгэмлэгийн сангуудын өмчлөх эрхийг нэг мөр шийдэж өгсөн байдаг.

Хөтөлбөрт мөн шашны эрх чөлөөний талаарх цаашдын үйл ажиллагааны төлөвлөгөөг ч тодорхой тусгажээ. Үүнд, Шашин шүтэх эрх, эрх чөлөөг хангах зорилгоор олон улсын хүний эрхийн стандартад нийцүүлэн хууль тогтоомж, үйл ажиллагааг хянан шалгах зэрэг олон үйл ажиллагааг тусгасан байна. Мөн ямар шашин гэдгээс үл харгалзан, шашны баяр наадмыг зөвшөөрөх, хоригдож байгаа болон ял эдэлж буй хүмүүстэй шашны баяраар нь уулзахыг зөвшөөрч дэмжлэг үзүүлэх, мусульман бус нийгэмлэгийн гишүүд, тэдний төлөөлөлтэй хамтран ажиллах, цаашид бусад шашнууд үйл ажиллагаа явуулах хууль эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зэрэг олон үйл ажиллагааны төлөвлөгөөг тусгасан байна[18]. Түүнчлэн сүүлийн үед Шашны хэрэг эрхлэх газрын тэргүүлэгчид болон имам төлөөлөгчид исламаас өөр бусад шашны нийгэмлэгийн төлөөлөгчидтэй энх тайван, ахан дүүсийн найрамдалтайгаар зэрэгцэн оршихыг хүсч байгаагаа байнга уриалж, нийтлэг соёл, түүхээрээ нэгдэж, нийгэм дэх хамтын ажиллагааг хөгжүүлэхийн төлөө байгааг илэрхийлэх болсон байна.

Тэгэхээр БНТУ-д орчин үеийн бүгд найрамдах, ардчилсан төр байгуулагдсан цагаас өнөөг хүртэл секулярист үзэл баримтлал янз бүрийн үе шатыг дамжиж ирсэн бөгөөд дэлхийн дахин глобалчлагдан, шашин шүтэх эрх, эрх чөлөөний ухамсар төлөвшихийн хэрээр улам өөрийн гэсэн хэв маягаа олж хөгжсөөр байна. Шашин шүтэх эрх, эрх чөлөөний институцийн үндсийг бий болгоход секулярист үзэл баримтлалыг чухалчлах нь дамжиггүй боловч түүнийг шашингүйн үзлийн шахалтын элемент болгон ашиглах нь, уламжлалт шашин соёлыг нь үл харгалзан, хэт олон төрлийн шашны номлолуудыг заавал оршин тогтнох, эрхийг заавал хангах ёстой гэсэн байдлаар гаднаас шүүмжлэх нь өрөөсгөл юм. Учир нь БНТУ өөрөө шашин соёлын давтагдашгүй түүхэн хэв маягт оршоор ирсний хувьд шашин шүтлэг, шашны эрх, эрх чөлөөний секуляризмын үүднээс шийдэж байхыг тулгах нь өөрөө нарийн төвөгтэй болж ирж байгаа юм[19].

АНУ-ын засгийн газрын нийтэлсэн тайлангууд юуны өмнө секуляризмын үзэл баримтлалын талаарх ойлголтын зөрүүтэй байдал үүсгэж байгаа нь онцлууштай. АНУ-ын тал, секуляризм, шашин, төр гэсэн гурван ойлголтыг өөр өөр үзэгдэл гэж ялгаж авч үздэг бол Туркийн хувьд энэ байдал нийгмийн бодит амьдрал дээр олон талаараа утга агуулгын хувьд давхцаж байдаг. Турк улсад

үндэсний уламжлалт шашин нь ялангуяа нийгэмд маш чухал байр суурь эзэлдэг бөгөөд энэ байдал нь мөн улс төртэйгөө нягт уялдаа холбоотой байдаг. Тухайлбал 2002 онд өөрийгөө "консерватив ардчилсан" гэж тодорхойлдог "АК парти" нам засгийн эрхэнд гарсан байдаг. Чингэхдээ АК парти нь консерватизм гэдэг дор юуг ойлгож байсан бэ гэвэл, иргэдийн буюу нийгмийн шашны хүсэлт хэрэгцээ, хүлээлтийг Төр засаг нь хангах ёстой гэсэн санаа байсан юм. Тиймээс АНУ-ын тайлан дээр дам утгаар хэлж байгаачлан Турк улс нь дарангуй секулярист биш, харин илүү консерватив ардчиллын хэлбэрээр явж байгаа нь харагдаж байна.

Бас нэг тэмдэглэх зүйл бол БНТУ-д шашны асуудлыг Ерөнхийлөгчийн дэргэдэх шашны хэрэг эрхлэх газар шийддэг. Энэ нь бүр Османы эзэн гүрний үеэс уламжлагдаж ирсэн цэвэр төрийн институт. Харин Америкад ийм чиглэлийн институт гэж байдаггүй. Тэр утгаараа Туркэд олон янзын шашин шүтлэг, итгэл үнэмшилд нийгмийн ухамсрын түвшинд болон институцын түвшинд хүлээцтэй хандаж, нээлттэй байхад түүх соёлын хэвшмэл үзэл нь саад бэрхшээл байж болох ч, хууль эрх зүйн талаасаа ч, нийгмийн амьдралын талаасаа ч, соёл уламжлалаа хадгалахын хажуугаар илүү ардчилсан чиглэлрүү явж байгаа нь илэрхий байна.

V. Дүгнэлт

Монгол Улс дахь сүүлийн үеийн шашны нөхцөл байдал болон гадаад дотоодын судлаачдаас төр, шашны харилцааны асуудлаар тавьж байгаа санал шүүмжлэлд үндэслэн Монголын төрөөс шашны асуудалд хандахдаа нэг талаас, олон улсын хүний эрхийн үзэл баримтлалыг, нөгөө талаас, монголчуудын үндэсний уламжлалт оюуны соёлын өвийг хамгаалан, үндэсний онцлогоо хадгалах үзэл санааг тусгах гэсэн чухал хоёр талыг аль алиныг нь авч үзэж бодлогоо боловсруулах шаардлага үүсэж байна.

Монгол дахь шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний байдлыг бүрэн тодорхойлохын тулд дараах хэдэн хүчин зүйлсийн асуудлыг нарийвчлан судлах шаардлагатай. Үүнд, 1) уламжлалт Бурханы шашин монголчуудын түүх, соёлын салшгүй хэсэг болох тул статусыг ялгамжтай авч үзэх, 2) өнөөгийн нийгэм дэх шашны дотоод, гадаад нөхцөл байдлыг ул суурьтай судлах, 3) гадаад орнуудын туршлага ба зохицуулалтыг харьцуулан судалж, авах гээхийн ухаанаар хандах, 4) дээр дурдсан хүчин зүйлсийн шинжлэх ухааны судалгааны үр дүнг төрийн бодлого боловсруулахад ашиглах шаардлагатай. Эдгээр асуудлыг цогцоор нь нарийвчлан судлалгүй зөвхөн аль нэг хүчин зүйлсийг голлон авч үзэх, түүнийг төрийн бодлогод яаравчлан тусгах нь хэт нэг талыг барьсан, туйлширсан үр дагавар гарах өндөр магадлалтай гэдгийг анхаарах нь чухал юм.

Төрөөс шашны асуудлыг хамгийн зөв арга замаар шийдвэрлэхэд шашныг олон талаас судлан объектив мөн чанарыг нь тодорхойлдог шинжлэх ухааны салбар болох Шашин судлалыг дэмжин хөгжүүлэх, төр нь шашны асуудалд хандахдаа шашин судлалын шинжилгээ судалгааг үндэс болгож байх шаардлага улам бүр өсөж байна. Үүнтэй холбогдуулан БНТУ-ын шашны хэрэг эрхлэх газрын жишээгээр төрийн алба байгуулж, шашин судлаачдыг шашны асуудал эрхэлсэн төрийн үйл хэрэгт татан оролцуулахад болохгүй гэх газаргүй.

Ашигласан материал

1. Лхагвасүрэн Г. (2004). Шашны талаарх Монгол төрийн бодлогын уламжлалаас / Шашин шүтэх, эс шүтэх эрх, эрх чөлөө. ред. Гантуяа М. Уб., 51 дэх тал
2. Батаа М. (2021). Уламжлалт Бурханы шашин, соёлын хэлмэгдүүлэлт ба сэргэлт: Олон нийтийн санаа бодол. Уб., 29 дэх тал
3. Батсайхан О, Лонжид З, Баатар С. (2021). Хэлмэгдэл ба цагаатгал: Түүх ба баримт. Уб., 74 дэх тал
4. Батсайхан О, Лонжид З, Баатар С. (2021). Хэлмэгдэл ба цагаатгал: Түүх ба баримт. Уб., 79 дэх тал
5. Батаа М. (2021). Уламжлалт бурханы шашин, соёлын хэлмэгдүүлэлт ба сэргэлт: Олон нийтийн санаа бодол. Уб., 60 дахь тал
6. Батаа М. (2021). Уламжлалт бурханы шашин, соёлын хэлмэгдүүлэлт ба сэргэлт: Олон нийтийн санаа бодол. Уб., 91 дэх тал
7. Батаа М. (2017). Буддын сүм хийдийн үйл ажиллагаа: Олон нийтийн санаа бодол. Уб., 25 дахь тал
8. Философийн хүрээлэн, ШУА. Монгол Улс дахь шинэ шашнууд: Нийгийн төрх, асуудал, шийдэл. (2020). Уб., 179 дэх тал
9. Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө. (2022). Уб., 2-3 дахь тал
10. Kaşaoğlu, T. (2016). Getting Turkey Back on Track to Democracy, Human Rights, and Religious Freedom. *The Review of Faith & International Affairs*, 14(2), pp. 14-22, 82
11. Ünlü, N. (2020). Amerika Birleşik Devletleri'nin Uluslararası Din Özgürlüğü Raporları: Türkiye Örneği. *International Journal of Social, Political and Economic Research*, 7(4), pp. 787-800, 796
12. International Religious Freedom Report. (2019). Turkey. <https://tr.usembassy.gov/wp-content/uploads/sites/91/Uluslararası-Dini-Ozgurlukler-Raporu-Turkiye-2019%E2%80%AF%E2%80%AF%E2%80%AF%E2%80%AF.pdf>. pp.10-11 (Date of access: 29.09.2022).
13. International Religious Freedom Report. (2020). Turkey. <https://www.state.gov/wp-content/uploads/2021/05/TURKEY-2020-INTERNATIONAL-RELIGIOUS-FREEDOM-REPORT.pdf>. pp. 7-20 (Date of access: 29.09.2022).
14. International Religious Freedom Report. (2021). Turkey. <https://www.state.gov/wp-content/uploads/2022/05/TURKEY-2021-INTERNATIONAL-RELIGIOUS-FREEDOM-REPORT.pdf>. pp. 8-22 (Date of access: 29.09.2022).
15. Kuru, A. T. (2011). Pasif ve Dışlayıcı Laiklik: ABD, Fransa ve Türkiye. İstanbul Bilgi Üniversitesi Yayınları. p. 18
16. Trthaber. (2020). Türkiye'den ABD Uluslararası Dini Özgürlükler Komisyonu raporuna tepki, <https://www.trthaber.com/haber/dunya/turkiyeden-abd-uluslararasi-dini-ozgurlukler-komisyonu-raporuna-tepki-480392.html> (Date of access: 29.09.2022).
17. Монгол Улсын Засгийн газар. (2021). Хүний эрхийн үйл ажиллагааны хөтөлбөр, Уб., 53 дахь тал
18. İnsan Hakları Eylem Planı. (2021). Özgür Birey, Güçlü Toplum; Daha Demokratik Bir TÜRKİYE, Adalet Bakanlığı, Mart. p. 58
19. Cozad, L. (2005). The United States' Imposition of Religious Freedom: The International Religious Freedom Act and India. *India Review*, 4(1), pp. 59-83.